



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-8

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хараат бус шинжээч томилох тухай/	4-8
--	-----

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны 04 дүгээр сарын 08-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 44 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Булгантуяа, О.Саранчулуун;
Чөлөөтэй: Ц.Баатархүү, Б.Бат-Эрдэнэ, Ж.Баясгалан, Б.Бейсен, Д.Ганмаа, Ц.Мөнхтуяа;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Баярмаа.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хараат бус шинжээч томилох тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан хараат бус шинжээчид нэр дэвшигч Ч.Энхбаяр, Л.Хоролсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Тогтоолын төсөл болон нэр дэвшигчдийн талаар Байнгын хорооны дарга Л.Энхнасан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Эрдэнэбат, Ж.Чинбүрэн, Д.Үүрийнтуяа нар үг хэлэв.

Л.Энхнасан: 1.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшигчийн мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагын талаар мэргэжлийн, хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр Чойжилын Энхбаярыг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшигчийн мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагын талаар мэргэжлийн, хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр Лхагвасүрэнгийн Хоролсүрэнг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хараат бус шинжээчдийг томилох санал дэмжигдсэн тул Байнгын хорооны тогтоол батлагдсанд тооцов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 17 минут үргэлжилж, 21 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 76.2 хувийн ирцтэйгээр 11 цаг 01 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Л.ЭНХНАСАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим 10 цаг 44 минут

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Л.Энхнасан: Байнгын хорооны эрхэм гишүүдийн өглөөний мэндийг дэвшүүлье.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Аюушийн Ариунзаяа гишүүн, Хөххүүгийн Болормаа гишүүн 10 дугаар тойрог, 6 дугаар тойрог Мөнгөнцогийн Ганхүлэг, 6 дугаар тойрог Цагаанхүүгийн Идэрбат, Сархадын Зулпхар гишүүн, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Мягмардашийн Сарнай, 2 дугаар тойрог Банзрагчийн Түвшин, 4 дүгээр тойрог Доржсүрэнгийн Үүрийнтуяа, 8 дугаар тойрог Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Сүхбаатарын Эрдэнэбат.

Өвчтэй Жудгийн Баярмаа, чөлөө авсан 10 дугаар тойргийн Цэндийн Баатархүү, 4 дүгээр тойрог Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Жадамбаагийн Баясгалан, Даваасамбуугийн Ганмаа, Цэндсүрэнгийн Мөнхтуяа нар чөлөө авсан. Мөн дотоод, гадаад, гадаад томилолттой 8 дугаар тойргийн Хүрэлбаатарын Булгантуяа, Отгоны Саранчулуун гишүүнд чөлөө авсан байна аа.

Ингээд ирц Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 57.1 хувьтай бүрдсэн тул Байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны хуралдаанаар өнөөдөр хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Байнгын хорооны тогтоолын төсөл Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, ЭМД-ын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонсгол хийх томилохтой холбогдуулан хараат бус шинжээчийг томилох тухай.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүд байхгүй тул хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 131.8-д Байнгын хороо нь нэр дэвшигчийн мэдлэг, мэргэжил, ур чадвар, ёс зүй туршлагын талаар мэргэжлийн хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчийг томилох ёстой.

Энэ хүрээнд хараат бус шинжээчээр бүртгүүлсэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголд оролцох хараат бус шинжээчээр Ч.Энхбаяр, ЭМД-ын Үндэсний зөвлөлийн гишүүний нэр дэвшигчийн сонсголд оролцох хараат бус шинжээчээр Л.Хоролсүрэн нар нэрсээ ирүүлээд байна аа.

Нэр дэвшигчийн мэдээлэл, хуулийн лавлагаа, Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Ер нь шинжээчид маань урилгаар ирсэн шүү. Энэ дээр бас анхаараарай, тийм. Хараат бус шинжээч томилохтой холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү? Тийм нэг л үг хэлчихье, нэг явчихъя. Үүрийнтуяа гишүүнээр Ариунзаяа гишүүнээр тасаллаа. Эрдэнэбат гишүүн үгээ хэлж асуултаа асууна уу? Ирцээрээ Ариунзаяа гишүүн ирцээрээ асуултаа асууж үгээ хэлнэ үү?

А.Ариунзаяа: Ирцээрээ дахиад л урд орлоо. Асуулт асуухгүй ээ 2 эрдэмтэн докторуудад амжилт хүсье. Тэгээд яг одоо өөрсдийнхөө саналаар орж ирж байгаад баярлалаа.

Нэг захих зүйл нь орж ирж байгаа үйлдвэрчний эвлэлээс санал болгосон 1, 1 л хүн байгаа тэгэхээр харьцуулалт байхгүй. Гэхдээ тэдгээр хүмүүсийг шууд дэмжиж явуулна аа гэсэн үг биш. Тэгэхээр яг одоо мэргэжлийн үүднээс маш сайн тодорхой зоригтой дүгнэлтээ гаргаарай гэж хүсье ээ. Дэмжиж байна аа. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Эрдэнэбат гишүүн асуултаа асууж, үгээ хэлнэ үү?

С.Эрдэнэбат: Нийгмийн даатгал дээр нэг зүйлийг асууя. Ер нь аль алинаас нь ер нь сангийнхаа одоогийн байгаа нөхцөл байдал дээр та бүгд маань эхлээд сайн танилцана уу, танилцаагүй бол сайн танилцаарай.

Хөндлөнгөөс бол дүгнэлт хийгээд шүүмжлэх магтах амархан. Яг байгаа бодит байдал амаргүй байгаа энэ сангууд ерөнхийдөө алдагдалтай шахуу, алдагдал алдагдалдаа энэ чигээрээ ингээд удаан явах юм бол бид нар нэг талаасаа бүх эмчилгээ, үйлчилгээ үнэгүй гээд тавьчихсан. Нөгөө талдаа төлдөг хүмүүс нь тийм өргөн хэр хэмжээнд биш. Тийм учраас маш хязгааргүй хэрэгцээг хязгаартай нөөцөөр хангах гэж оролдох гээд тэгээд тэр нь болохгүй болохоор үндсэндээ өнгөрсөн жил бол эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилт үндсэндээ бараг сүүлийн сар бол тасарсан.

Тийм учраас бол энэ зүйл дээр та бүгд маань энэ сангийн үйл ажиллагааны менежментийн асуудал их чухал байгаа. Тэгэхдээ менежмент гэхээсээ илүү энэ Их Хурлаас хамааралтай. Үндэсний зөвлөлийн гишүүд харин манай мэргэжлийн яамд ч гэсэн асуудал байвал дор дор нь хурдан оруулж ирэхгүй бол нэг талаасаа манай улс төрч нар бол ард түмэнд халагдах гээд бүгдийг нь үнэгүй, бүгдийг нь хөнгөлнө тэгнэ гээд тавьчихдаг. Нөгөө талаасаа маш олон тэр үйлчилгээнүүдийг чанартай болгохоор мэдээж зардал өртөг байдаг. Тэгээд энэ тал дээр нь та бүгд маань ингээд энэ үндсэн энэ сангийн үйл ажиллагаануудтай нэлээн сайн танилцаарай гэдгийг эхлээд хэлмээр байна.

Хоёрдугаарт бол хоёулаа ерөнхийдөө багш. Багш нарын яах вэ нэг тал нь юу болох вэ гэхээр нөгөө оюутнуудаасаа шалгалт авч байгаа юм шиг. Тест иймэрхүү байдлаар ингээд аваад нэг хэт нэг талаас харсан өрөөсгөл дүгнэлт хийчих вий дээ. Хамгийн гол нь энэ нийгмийн даатгал, ЭМД-ын үндэсний зөвлөлийн гишүүд маань өөрсдөө тодорхой нийгмийн бүлгүүдийн төлөөлөл даатгуулагчийн төлөөлөл гэдэг байдлаар энэ удаад орж ирж байгаа.

Тийм учраас энэ тал дээр нь хэр зэрэг ашиг сонирхлын зөрчилтэй вэ. Хэр зэрэг эргээд энэ сангийн үйл ажиллагааг хараат бусаар удирдаж зохион

байгуулахад нь нөлөөнд автах магадлал, хамаарал бүхий этгээд гэдэг зүйл дээр нь илүү их анхаараарай.

Өнгөрсөн хугацаанд ингээд харж байхад мэдлэгтэй, чадалтай, тийм эрдэмтэн, тийм доктор гээд ороод ирдэг. Яг ашиг сонирхлын юман дээр дандаа буруу эсрэг энэ даатгуулагчдын санхүү хөрөнгөд эрсдэл учруулсан шийдвэрүүдийг эрх мэдэл бүхий хүмүүсээ дагаад гаргаж байсан ийм гашуун туршлага байгаа.

Тийм учраас бол энэ зүйл нь их чухал гэдгийг хэлмээр байна аа.

Ингээд 2 дэвшигчдэдээ амжилт хүсье ээ. Тэгээд зориг гаргаж орж ирсэнд баярлалаа. Нөгөө талаараа энэ сангийн хамгийн том 2 сан учраас бид нар маш их санаа зовж байгаа. Магадгүй манай энэ Байнгын хорооны хамгийн анхаарал татахуйц ийм 2 сан энийг зөв сайн авч явах ийм шаардлагатай. Нийгмийн хүлээлт ч гэсэн маш өндөр байгаад байдаг.

Тийм учраас энэ тал дээр анхаарч ажиллаарай гэж хүсье.

Л.Энхнасан: Баярлалаа. Эрдэнэбат гишүүнд. Үүрийнтуяа гишүүн асуултаа асууж үгээ хэлнэ үү.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Та бүхэндээ өглөөний мэнд хүргэе.

Эрүүл мэндийн даатгал, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн гишүүдийг сонгоход хараат бус шинжээчээр ажиллахаар орж ирж байгаа өнөөдрийн 2 экспертийн хувьд бол харьцангуй туршлагатай дадлагатай, энэ чиглэлийнхээ ажлуудыг өмнө нь судалгааны ажил, эрдэм шинжилгээний ажилд нь хамтраад оролцчихсон боломжийн 2 нэр дэвшигч ороод иржээ гэж ингэж харж байгаа. Би одоо Энхбаяр багшийг бол МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг олон жил удирдсан. Энэ чиглэлээр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гэхээс илүү менежментийн менежерийн хувьд нөгөө талдаа олон төсөл хөтөлбөрүүд дээр баг хамт олноороо орж байсны хувьд илүү өргөн цар хүрээнд харчих боломжтой хүн гэж дүгнэж саналаа өгч орж ирсэнд нь талархаж байна.

ЭМД-ын Үндэсний зөвлөлийн гишүүнийг сонгох энэ сонсголыг миний бие ахалж ажиллахаар Байнгын хорооны даргаас үүрэг авсан.

Тийм учраас Хоролсүрэн шинжээчийн хувьд бол одоо бид бас энэ дээр нэлээн хамтарч ажилла ийм хэрэгцээ шаардлага үүсэх байх аа гэж ингэж харж байгаа. Тэгэхээр аль болох энэ даатгалын үндэсний тогтолцоог бодитой хадгалаад явахад өөрийн үнэтэй хувь нэмрээ оруулах, өөрийн мэдлэг боловсрол, авьяас чадвараа хоёргүй сэтгэлээр зориулчих ийм л чадвартай туршлагатай нэр дэвшигчдийг оруулж ирэхэд л та бүхний дүгнэлт ач холбогдол орших юм аа. Тийм болохоор энэ дээр хараат бусаар өөрсдийн мэргэжил арга зүйн хувьд тэр хүмүүсийн хийх ажлын байрандаа шаардлага хангах эсэхийг нь тодорхойлоход бол хангалттай хэмжээнд дүгнэлт гаргачих хэмжээний шинжээчид байна аа гэж дэмжсэн саналыг хэлж байна.

Л.Энхнасан: Баярлалаа. Чинбүрэн гишүүн үгээ хэлж, асуултаа асууна уу.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Би Нийгмийн бодлогын байнгын хорооноос та бүгдэд баярлалаа гэж хэлье. Ер нь бид нэг ийм бодлогоороо арай тийм мэргэжлийн улсууд оруулж ирж ЭМД-ын Үндэсний зөвлөлд сонгогдох гэж байгаа улсуудыг үнэлэх хүн маань өөрөө энэ нийгмийн эрүүл мэнд, эдийн засаг ойлгодог, дээрээсээ энэ хуулийнхаа үзэл санааг мэддэг байх өөрөө их чухал л даа. Тэгээд өнгөрсөн Байнгын хорооны хурлаар хэлээд байсан зүйл бол миний гол санаа энэ. Жишээлэх юм бол өнөөдөр ЭМД-ын ерөнхий газраас гаргачхаад байгаа тогтоол тушаал шийдвэр нь хууль давсан юмнууд л гарчхаад байгаа юм. Жишээлэх юм бол бид өнгөрсөн төсвөөс хамааралтай эрүүл мэндийн салбараа аль болох л хязгаар тавьдаггүй. Хүний өвчнийг хязгаарлаж ийм буруу тогтолцоо хийхгүй цэвэр өрсөлдөөн, чанарын өрсөлдөөн үнийн биш шүү. Ийм юм хийгээсэй гэж бодож хууль баталсан. Хуулийн хэрэгжилт 2021, 2022 онд бол ковид цар тахалтай үед их тийм дэмжлэг болж чадсан. Тэгээд одоо буцаагаад бүр хязгаарлалт тавиад хийсэн, хөдөлмөрлөснийх нь 20, 30 хувийг нь хасдаг, хязгаарлалт тогтоодог, үйл ажиллагаа явуулах боломжгүй хэмжээнд хүртэл болгох гээд байгаа ийм нөхцөл байдал үүсээд байна шүү дээ.

Тийм учраас ЭМД-ын Үндэсний зөвлөлд орох гэж байгаа хүмүүсийн үзэл санаа харж байгаа өнцгийг мэдэж, тэдгээрээс ярилцлага авч, тэдгээрт тэнцэх эсэхийг тогтоох гэж байгаа ийм 2 хүн маань мэргэжлийн хүн орж ирсэн. Ялангуяа эрүүл мэндийн чиглэлд энэ Лхагвасүрэнгийн Хоролсүрэн эдийн засагч, нийгмийн эрүүл мэнд, хелл экономист гэдэг байх аа. Ийм мэргэжлийн хүн ороод ирсэн нь их таатай байна. Бид одоо өнгөрсөн парламент 2 хувьтай болгоод өгсөн. Эрүүл мэндийн тусламжийн тухай хууль 2018 оноос хэрэгжиж хэрэгжих ч гэж дээ хэрэгжиж чадаж байгаа ч юм уу. Нөгөөдөх нь нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн ийм Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн тухай хууль батлаад өгчихсөн. Одоо энийгээ ажил болгох ёстой байхгүй юу. Тэгээд аваачаад даатгуулагчийн мөнгөнөөс нийгмийн эрүүл мэндийн тусламжийнхаа мөнгийг гаргаад байж болохгүй шүү дээ.

Энэ чинь Засгийн газрын өөрийнх нь хийх ёстой төсөвт нь суух ёстой санхүүжилт нь байх ёстой.

Дээрээс нь тэр эрүүл мэндийн эрт илрүүлэг хийж байгаа тэр төсөв мөнгийг нь хараарай. Хийхийн эцэсгүй битгий хийгээсэй гэсэн юм шиг юм хийж байдаг. Тэгэхээр энэ дээр одоо та бүхэн анхааралтай та 2 маань анхааралтай ажиллаасай. Тэр нэр дэвшүүлээд орж ирэх гэж байгаа улсууд даатгуулагчийг хамгаалж үнэхээр чадаж байгаа юм уу, өвчин тусаад ядуурах юм уу, ядуурахгүй юм уу? Энэ асуудлыг нь шийддэг байх хэрэгтэй.

Дээрээс нь хэнийг ч орхигдуулахгүй байх энэ эрүүл мэндийн тусламжийн гол үзэл санаа энд хаягдаж болохгүй шүү дээ, тийм ээ. Хүн бүрд хүрдэг байх бид газрын баялаг хэчнээн их зүйл байгаа билээ. Энийгээ ашиглаад, нэг минут нэмчихье тэгээд л болоо.

Л.Энхнасан: Нэмэлт нэг минут.

Ж.Чинбүрэн: Жишээлбэл баялгийн сан Учрал сайдын яриад байгаа Баялгийн сан байна. Баялгийн сан бол дотроо эрүүл мэнд, боловсрол 2-т санхүүжилт зарцуулж болно гээд байгаа. 360 тэрбум төгрөгийн өртэй болчихсон. Даатгалын сан. Үндэсний зөвлөл нь энэ дээр даатгалын газраа шалгаж байна гэсэн нэг юм яваад л байна лээ. Тэгээд бүүр нэг ийм бүтээлч биш байдал энэ салбарыг

ерөөсөө татаж нураалаа унагаалаа. Өвчин тусаад хүн эмчлүүлж бүрэн эмчлүүлж чаддаг байх төсөв нь хангалттай байх л хэрэгтэй байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ үндсэн концепцыг та бүхэн тэр асуулгадаа үнэлгээндээ оруулахдаа хянаарай. Хоролсүрэн энэ дээр онцгой анхаарч ажиллаарай бид бүгдээрээ дэмжинэ ээ. Гол нь тэр Үндэсний зөвлөлд ороод ажиллаж байгаа хүн маань үнэхээр сэтгэлтэй зүрхтэй. Үгүй ээ энэ чинь анхан шатаараа эмнэлгүүдээрээ яваад үз л дээ. Хар л даа. Тэр санхүүжилт нь хүрэхгүй байгааг үз л дээ.

Л.Энхнасан: Баярлалаа. 2 хараат бус шинжээчээр нэр дэвшиж байгаа Энхбаяр, Хоролсүрэн нартаа амжилт хүсэж гишүүдийн хэлсэн саналыг дүгнэлт үнэлгээ хийхдээ ажил хэрэг болгож үнэлээрэй. Та хоёртоо амжилт хүсье.

Гишүүд үг хэлж, асуулт авч дууслаа. Байнгын хорооны хуралдаанд оролцогчийн гишүүдийн 3-ны 2-оос доошгүй саналаар томилох тул та бүхэн 8 хүнээр дэмжинэ. Тийм болохоор идэвхтэй оролцохыг сануулж байна.

Нэгдүгээрт Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл. Даатгуулагчийн төлөөлсөн гишүүнд нэр дэвшигчийн мэдлэг мэргэжил, ур чадвар, ёс зүй, туршлагын талаар мэргэжлийн хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр Ч.Энхбаярыг томилъё гэсэн томъёоллоор санал хураалт хийе ээ.

75 хувиар санал дэмжигдлээ.

Баяр хүргэе.

Хоёрдугаарт, ЭМД-ын үндэсний зөвлөл. Даатгуулагчийн төлөөлсөн гишүүнд нэр дэвшигчийн мэдлэг мэргэжил, ур чадвар, ёс зүй, туршлагын талаар мэргэжлийн хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчээр Хоролсүрэнг томилъё гэсэн санал хураалт хийе ээ.

75 хувиар дэмжигдлээ.

Санал хураалт дэмжигдсэн тул тогтоолын төсөл батлагдлаа.

Горимын санал гэж байхгүй. Горимын санал тэр чинь одоо горимын санал чинь байхгүй шүү дээ. Ирэх 7 хоног хурлаа зарлана. 14-нд тиймээ.

Нийгмийн бодлогын байнгын хорооны хурал сонсголоо ирэх 7 хоногт. Үүрийнтуяа, Идэрбат гишүүн тийм.

Өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул хурал хаасныг мэдэгдье ээ.

11.01 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА